



# OTP нууц үг үүсгэгч гэж юу вэ?

OTP /One Time Password/ нь нэг удаагийн нууц үг үүсгэгч бөгөөд интернэт банк үйлчилгээнд нэвтрэхэд ашигладаг нууцлал, хамгаалалтын мобайл аппликэйшн юм.

## Хэрхэн ашиглах вэ?

### а. Гар утасны аппликэйшнийг татна.

Хайлтаар гарч ирсэн аппликэйшнийг сонгон **Install** эсвэл **Download** товчийг дарж утсандаа суулгана.


| iPhone                                                                              | Android                                                                              |
|-------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|
| App Store-оос TDB эсвэл OTP гэж хайна.                                              | Play Store-оос TDB эсвэл OTP гэж хайна.                                              |
|  |  |

### б. Банкнаас ирсэн сериал дугаар идэвхжүүлэх кодыг ашиглан тохиргоог хийнэ.


1-р алхам: Сериал дугаарыг бүртгэл хийлгэсэн банкны ажилтнаас авна.

2-р алхам: 4 оронтой тоо бүхий идэвхжүүлэх код таны и-мэйл хаягт илгээгдэх эсвэл гар утсанд тань мессэжээр ирнэ.


3-р алхам: Дээрх 2 мэдээллийг ашиглан тохиргоог хийн нууц үг үүсгэгчийг ашиглана.




Тохиргоо цэсрүү орно



Сериал цэсрүү орно



Шинэ товчийг дарна




Холбогдох банкнаас авсан мэдээллүүдийг оруулах ба "Тайлбар" хэсэгт дурын утгыг оруулна

с. Сериал дугаар, идэвхжүүлэх кодыг тохируулсаны дараа тохиргоо цэсрүү орон цагийг автоматаар сонгон хадгална.



Цаг цэсрүү орно




Автоматаар сонголтыг сонгоно



Гарч ирсэн цонхны доорх “Хадгалах” товчийг дарна

d. Нууц үг үүсгэгчээ ашиглана



Сумын дагуу дэлгэцийг зурснаар нэг удаагийн нууц үг үүснэ. Та тус нууц үгийг интернэт банк үйлчилгээний гүйлгээ баталгаажуулах эсвэл нэвтрэх хуудасны “**ОТР код**” талбарт бичиж оруулна.